

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255001>

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ ТҮҮХЭН ОЙРОЛЦОО БА ЭСРЭГ
УТГАТ НЭГЖИЙН ТУХАЙ

Д.Бадамдорж

Хураангуй: Эл эрдэм шинжилгээний өгүүлэлд “Монголын Нууц Товчоо” (МНТ)-ны утга судлалын судалгааг зарим талаар нарийвчлан хийх зорилго тавьж, түүний судлагдахуун бүрийг товчоолох шаардлагын үүднээс бид эл зохиолын түүхэн ойролцоо утгат ба эсрэг утгат нэгжүүдийг сонгож судалсан болно. 785 жилийн тэртээ оюунлаг монгол хүний тархины үйлээр бүтээсэн энэхүү гайхамшигт бүтээлийг зохиогчид нь үгийн сан, утга зүй, найруулга зүйн зохих мэдлэг боловсролтой байжээ. Энэхүү бичгийн мэдлэг боловсролтой хүмүүс байсан нь монгол хэлний түүхэн утга судлалын судлагдаадүй асуудлыг мөшгиж, түүхэн **ойролцоо** утгат үг (үглэвэр), хэлц, өгүүлбэр, түүхэн **эсрэг** утгат үг (үглэвэр), хэлц, өгүүлбэр мэтсийн гүн бүтцийг судлахад тодорхой мэдэгдэж байлаа.

“Монголын Нууц товчоо”-ны хэлнээ: 58§. ... Ambayai qayan-u **ösül ösün, kisal kisan** yadaba. (өсөл-хясал), 167§. ... čaγaan-a **sačaasu**, qara-ča **qaqaasu** ... (сацах- хахах) гэх мэт ойролцоо утгат нэгж, 5§. Dobun **mergen**, 23§. Bodončar **mungqay** (мэргэн-мунхар), 254§. ...**manglay-yin kölesün ula-dur kürtele, ula-yin kölesün manglay-dur** γartala ... (магнай-ул) (МНТ. 1985. бүх жишээг эл бүтээлээс авав.) гэх мэт эсрэг утгат нэгж бол бичгийн боловсролтой монгол хүн утгад шүтэж, хэлний нэгж хоорондын утгын харьцаа хамаарлыг гүн сэтгэн бодож, найруулан бичсэн түүхэн утга судлалын, сонирхол татсан судлагдахуун юм. Дунд үеийн монгол хэлний үнэт дурсгал болсон “Монголын Нууц Товчоо”-ны хэлийг өдгөөгийн онолын утга судлалын үзэл баримтлалаар ажиглахад, монгол хэл, хэлэхүйн түүхэн хөгжил нэлээд өндөр түвшинд байсан нь ажиглагдаж байлаа.

Түлхүүр үг: Монголын Нууц Товчоо, түүхэн ойролцоо ба эсрэг утгат үг.

Keyword: The Secret History of the Mongols, historical synonyms and antonyms.

Удиртгал

“Монголын Нууц Товчоо”-ны хэлний **утга судлалын** талаар хэл шинжээчид сүүлийн үед сонирхон судалсаар байна. Тухайлбал: Ш. Гаадамба (1990), Д. Цэрэнсодном (2008), С. Мөнхсайхан (2023) нарын зэрэг судлаачид судалгааны бүтээл бичсэн байна. Монгол хэлний түүхэн утга судлалын асуудлыг онол дадлагын үүднээс нарийвчлан судлахын тулд “Монголын Нууц Товчоо” хийгээд түүний өмнөх ба хойнох бичгийн дурсгалын баримтуудад тулгуурлах нь дамжиггүй юм. “Монголын Нууц Товчоо”-ны хэлний олон нэгж хоорондын утгын шүтэлцээ хамаарал буюу ойролцоо ба эсрэг утгыг эл өгүүлэлдээ зориуд авч үзлээ. Аливаа хэлний нэгжүүдийн ойролцоо ба эсрэг утгас бол тухайн хэлээр хэлэлцэгчдийн сэтгэн бодох үйлтэй гүн гүнзгий холбоотой учир XIII зууны үеийн бичгийн

утга зохиолын хэлний утга судлалын бүхий л үзэгдэл монголчуудын сэтгэхүй, сэтгэлгээтэй уялдаж байдаг ажээ. Бид тэр үеийн монгол хэл сэтгэхүйн өвөрмөц холбоог илрүүлэх зорилго тавьсан юм.

Монголын Нууц Товчоо судлал бол дорно, өрнө дахинд ихэд дэлгэрч, 30 гаруй орны судлаачдыг хамрах болжээ. Дараах тоо баримтаас илэрхий байна. Үүнд:

Судалгааны агуулга	тоо баримт
- Эх бичгийн судалгаа /судлаач/	770
- Эрдэм шинжилгээний ном	217
- Эрдэм шинжилгээний өгүүлэл	4386
- Эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл	171
- Зурагт ном	159 (Пүрэвжав, Э. 2023)

нийтэлжээ.

Миний бие, “Монголын Нууц Товчоо”-ны утга судлалын судалгааг үргэлжлүүлэн хийхийн тулд “МНТ дахь урлагийн тухай мэдээлэл” (2022), “МНТ-ны их хэмээх үгийн утга” (2023), “МНТ дахь өнгө зүсэм нэрлэсэн үгсийн утга” (2024), “МНТ-ны түүхэн метафорын утга” (2025) гэх зэрэг эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлээд байгаа болно.

1. Судалгааны зорилго: XIII зуун буюу дундад үеийн монгол хэлний утга судлалын зарим үзэгдлийг нарийвчлан шинжлэх, ялангуяа, “Монголын Нууц Товчоон”-ы хэлийг онолын утга судлалын үүднээс судлах, монголчуудын хэлний нэгж хоорондын утгын харьцаа хамаарал болон сэтгэхүй, сэтгэлгээг тодруулах.

2. Судалсан байдал: “Монголын Нууц Товчоо”-ны ойролцоо ба эсрэг утга нэгжийн талаар тусгайлан судалсан зүйл үгүй боловч, эрдэмтдийн бүтээлд цухас дурдсаар иржээ. Саяхан С. Мөнхсайхан “Монголын Нууц Товчооны үгийн сан, утга зүйн бүрдүүлбэр” (Уб. 2025) гэсэн нэг сэдэвт зохиолдоо, “МНТ”-ны хэлний ойролцоо утгатай үгсийн гурван тохиодол, эсрэг утгатай үгсийн мөн гурван тохиодол, эсрэг утгатай ба ойролцоо утгатай хоршоо үг зэргийг жишээгээр тайлбарласан шинэлэг судалгаа хийв.

3. Судалгааны хэрэглэгдэхүүн: Монголын Нууц Товчоо, судалгааны ном зохиол, толь бичиг,

4. Судалгааны арга: Хэл шинжлэлийн товчоолох, түүхэн арга гэх зэрэг аргаар судалсан.

5. Судалгааны ач холбогдол: Монгол хэлний түүхэн утга судлалын судалгааг ирээдүйд ул суурьтай хийхэд одооноос зарим нэгэн судлагдахууныг нарийвчлан судалж, суурь тавих ач тустай юм.

1. Судалгааны хэсэг

“Монголын Нууц Товчоо”-ны үгийн сангийн бүрэлдүүлбэр хэсэг болсон үглэвэр, хэлц болон бүхэл бүтэн өгүүлбэр зэргийн өөр хоорондын утга, утга санааны хамаарлыг ажиглахад, түүхэн ойролцоо ба эсрэг утгат нэгжийг өргөн дэлгэр хэрэглэсэн байна.

НЭГ. ОЙРОЛЦОО УТГАТ НЭГЖ

“МНТ”-ны хэлнээ ойролцоо утгат нэгжийг сонгон хэрэглэсэн баримт цөөнгүй байна. Тухайлбал:

1.1. Шим ертөнц, хүний үйлтэй холбоо бүхий ойролцоо утгат үгс, түүний утга, найруулга, хэрэглээний тухай жишээгээр тайлбарлая. Жишээ нь:

11§. Tedüy atala Duwa soqor aqa inu **ügei bolba**.

268§. Gaqai jil Činggis qayan **tenggeri-dür yarba**.

164§. Bi ber edöe ötölbe. Namayi ötöljü **ündüd-te yaruasu** qaučidba bi, qaučidču **qaltud-ta yaruasu** qamuу ulus ken medekü.

127§. ...sübee **sečijü**, qabirya **qadquju** yakin qayačaulba ta,

58§. ... Ambayai qayan-u **ösül ösün, kisal kisan** yadaba.

78§. ... **qaučin üges** qadalun, **ötögüs üges** orkidun ...(МНТ. 1985 бүх галигийг эл бүтээлээс авсан)

Энд **үгүй болов-тэнгэрт гарав-өндөрт гарваас-хаданд гарваас; сэжиж-хатгаж, өшил – хясал, хуучин үгс-өтгөс үгс** гэх мэт ойролцоо утгат нэгж буй нь үгийн сангийн найруулгыг утга төгөлдөр болгожээ. Мөн хүүхэд залуучуудын сэргэлэн цовоо байдлыг “62§. Nidün-dür-iyen **γaltu** ni’ur-tur-iyen **geretü kö’ün bui**.” (Нүдэндээ **галт**, нүүрэндээ **гэрэлт** хөвүүн буй.) хэмээн “галт, гэрэлт” гэх ойролцоо утгат үгээр дүрсэлсэн байдаг агаад монгол аман зохиол болон утга зохиолд давтамжтай уламжлан хэрэглэсээр иржээ.

1.2. Сав ертөнц, байгалийн үзэгдэлтэй холбоотой ойролцоо утгат нэгжийн утга, найруулга, хэрэглээний тухай жишээгээр авч үзье. Жишээ нь:

108§. **Boroan** ber boluasу boljal-dur, **qura** ber boluasу qural-dur bü qojidaya.

72§. ... čeel usun **niduralua**, čegen čilaun **čauralua** keejü.

167§. ... čaуaан-a **sačaasu**, qara-ča **qaqaasu** ... гэх мэт.

Энд бороо-хур, ширгэлээ-цуурлаа, сацвал-хахвал гэсэн ойролцоо утгат үгсийг хэрэглэж, монгол хэлний үгийн сан, утга судлалын мэдлэг бүтээж байжээ.

1.3. Ялангуяа, хоршоо үгийг ойролцоо утгат үгээр бүтээж, үлэмж тоогоор хэрэглэсэн байдаг. Жишээ нь:

133§. Ebüges ečiges (өвгөс эцэгс), 146§. Qayilan ууулан (хайлан уйлан), 279§. üge’ün duta’un (үгээгүү дутуу), 240§. Öglige soyurqal (өглөг соёрхол), 214§. Nači tusa (ач тус), 187§. Jisüjü qubiyaju (зүсэж хувааж) гэх мэт. Энэ бол монгол хүн ойролцоо утгат үгсийг танин мэдэж, хэрэглэснийг гэрчилж байна.

1.4. “МНТ”-ны хэлнээ ойролцоо утгат 12 тодотгол гишүүн өгүүлбэр хэрэглэсэн байгаа нь монгол хэлний гүн бүтцийг судлахад товтой баримт болох бөгөөд бидний судалгааны сонирхлыг ихэд татаж байна. Тухайлбал,

Өэлүн үжин: Тэмүжин Хасар нарыг 12 амьтантай зүйрлэсэн нь:

Qarbisu-ban qajaqu qasar noqay metü,

Aur-iyen darun yadaqu arslan metü,

Seüder-tür-iyen dobtulqu singqor metü,

Botoyan-iyen borbi qajaqu buura metü,

Köüd-iyen idekü anggир metü,

Bariju ülü saaraqu bars metü,

Qada-dur dobtulqu qablan metü,

Amida jalgisu kekü mangyus metü,

Sem-iyer jalgiqu čuraqa metü,

Boroyan-dur siqaqu čino metü,

Kebtesi-ben köndeesü ömerkü čöeböri metü,

Balamud dobtulqu baruq metü. (МНТ-ны §78)

Эл арван хоёр тодотгол гишүүн өгүүлбэр бол араатны араншинг илэрхийлсэн утга санаагаараа ойролцоо утга санаатай байж, ер монгол хүн тэдгээр амьтдыг танин мэдсэн мэдлэг учраас танин мэдэхүйн утга зүйн үүднээс ч тайлбарлаж болох ихэд сонин бүтэц өгүүлбэрүүд юм.

Мөн ойролцоо утга санаа бүхий өгүүлбэрүүдээр бодит амьдарл, үйл явцын талаар гүн гүнзгий дүрслэн илэрхийлж байжээ. Жишээ нь: “МНТ”-ны 72§. ...čeel

usun niduralua (Цээлийн ус тасарлаа.) хэмээсэн нь Өэлүн үжин болон хөвүүдийг Тайчууд орхин нүүсэн харамсалтай байдлыг дүрслэн илтгэсэн утга санаатай өгүүлбэр болно. Мөн **čegen čilaun čauralua** (Цэгээн чулуу цуурлаа.) хэмээх ойролцоо утга санаа бүхий өгүүлбэрээр хослуулан дүрслэн хэлсэн байдаг. Ийнхүү ойролцоо утга санаа бүхий өгүүлбэрүүдийг цөөнгүй хэрэглэсэн онцлогтой юм. Бас нэгэн жишээг авч үзье. “МНТ”-ны 76§. ...**seüder-eče busa nökör ügei** (Сүүдрээс өөр нөхөр үгүй), **seül-eče busa čičua ügei** (Сүүлнээс өөр ташуур үгүй). Эл хоёр өгүүлбэр бол хоёул харамсмаар боллоо гэсэн ойролцоо утга санаа бүхий буй нь илхэн байна. Ойролцоо утга санаа бүхий өгүүлбэрүүдийг тухайн үеийн байдлыг үнэлж дүгнэх, тордовч тус болохгүй, харамсах аястайгаар л хэрэглэж байсан ажгуу. Жишээ нь: “МНТ”-ны 255§. ... **öleng-dür qučiasu hūker-e ülü idegdekü** (Өлөнд хучивч, үхэр үл идэх), **öökün-dür qučiasu noqay-a ülü idegdekü** (Өөхөнд хучивч, нохой үл идэх) гэх мэт.

1.5. Хэлцийн бүрэлдүүлбэрт ойролцоо утгат үгийг түгээмэл сонгон хэрэглэж байжээ. Жишээ нь: 64§. ... **je’e-yin jisün, ökin-ü önggeten**. ... (зээгийн зүсээр, охидын өнгөөр ... МНТ. 1957), 77§. ... **nidün-ü surmusun, aman-u qayasan bolıamui ta**. (Нүдний сормуус, амны бөөлжис болгоно. МНТ. 1957), 79§. ..., **qoıuıad qoojıjuu silüged siberijüü** ..., (Хулхи нь гуужиж, шүлс нь сэвэрчихлээ. МНТ. 2000) (Хурганы үс гуужив, төлөгний бие төлжив. МНТ. 1957), 121§. **ke’eli nigeten, keke ıayčatan**. (Хээл нэгтэн, хэхий гагцтан МНТ. 2000) гэх мэт. Эл жишээ баримтад буй “зээ-охин, сормуус-бөөжис, гуужих-төлжих, нэгтэн-гагцтан” гэх мэт ойролцоо утгат нэгжүүд нь монгол хэлний үгийн сан, утга зүй, найруулгын түүхэн баримт болж байна.

ХОЁР. ЭСРЭГ УТГАТ НЭГЖ.

“МНТ”-ны хэлнээ эсрэг утгат нэгжийг сонгон хэрэглэсэн баримт олон байна. Тухайлбал:

2.1. Шим ертөнц, хүнтэй холбоотой эсрэг утгат үгс цөөнгүй. Жишээ нь:

5§. Dobun **mergen**,

23§. Bodončar **munıqay**.

65§. **Nu(yun) köüd manu nuntuy qarayı,ökin köün manu öngge üjegdeyü** гэх мэт. Энд **мэргэн-мунхаг, нуган хүү-охин хүү** гэсэн эсрэг утгат үгсийг хэрэглэж, эсрэгцүүлэн сэтгэж, хүний шинж байдлыг илтгэсэн ажээ.

2.2. Сав ертөнцийн юмстай холбоотой эсрэг утгат үг, хэлц үлэмж хэрэглэж байжээ. Жишээ нь: 254§. **Hodutay tenggeri horčıju bülee**. ... **Körisütey etügen körbeju bülee**. Энд **тэнгэр-газар** хэмээх эсрэг утгат хоёр нэр үг, **орчиж-хөрвөж** хэмээх ойролцоо утгат хоёр үйл үгийг сонгон холбож, дээр доор үгүй л үймж байгааг дүрслэн хэлжээ.

2.3. Өнгө, хугацаа, орон зай ба хөдөлгөөн зэргийг илэрхийлсэн түүхэн эсрэг утгат үг, хэлц зэргийг давтамжтай сонгосон ажээ. Жишээ нь:

210§. ...**qara söni gendü čino, gegeen üdür qara kerie**...,

195§. ...**Odčigin ... erte untayči, oraya bosuyči** ...,

199§. **Bidan-i ečine ber böesü ile metü, qolo ber böesü oyira metü sedkijü**...

24§. ... **üküsü inu ükü sügey aasu inu asuyay** ... гэх мэт.

Энд **хар шөнө-гэгээн өдөр, эрт унтагч-орой босогч, далд-ил, хол-ойр, үхвэл үхье, сэтвэл, сэхье** (МНТ. 2000) гэсэн эсрэгцэл хэрэглэж, утга, найруулгыг эрчимжүүлжээ.

2.4. Эсрэг утгатай өгүүлбэр нэлээд хэрэглэсэн ажээ. Жишээ нь: “МНТ”-ны хэлнээ:

66§. **Olontau** γuyuulju ögbesü **deejilegdekü**, **čöenteü** γuyuulju ögbesü **doromjilaydaqu...**

254§. ...**manglay**-yin kölesün **ula**-dur kürtele, **ula**-yin kölesün **manglay**-dur γartala ...

81§. **Deeltü** töregsen köün bi ajuu je. **Ničügün** töregsen köün sauju či ajuu je.

Энд эсрэг утгат үгэнд түшиглэж, эсрэг утгатай өгүүлбэр бүрэлджээ. Мөн үглэврийн утгад тулгуурлаж, өгүүлбэрийн утга санаа эсрэгцсэн найруулга бүхий түүхэн солбиулал хэрэглэж байжээ. Жишээ нь:

Д.Цэрэнсодном 165 §. ...Сэнгүм өөрөө ихэмсэглэн бодож өгүүлрүүн: “Бидний ураг эдэнд очвоос **үүдэнд** сууж, эгнэгт **хоймор** харах ажгуу. Эдний ураг бидэнд ирвээс **хоймор** сууж, **үүд** харах ажгуу...” (**үүд - хоймор**) (МНТ. 2000) гэж хөрвүүлжээ. Т. Дашцэдэн 165 § ... “Senggüm öer-iyen yekejilen sedkijü ügülerün. Bidan-u uruy an-dur oduasu **alaun-a** bayiju eenegče **qoyimar** qaraqu ajuu. Anu uruy bidan-dur ireesü **qoyimar-a** sauju **alaun-a** qaran ajuu.” (**alaun-a-qoyimar**) (МНТ. 1985) гэж галиглажээ. Ийм баримт цөөнгүй байна.

2.5. Эсрэг утгат үгээр хоршоо үг бүтээж, өргөн дэлгэр хэрэглэсэн байдаг. Жишээ нь:

35§. Mawu sayin (муу сайн), yeke ücüken (их өчүүхэн), teriü šiyira (түрүү шийр),

74§. üdür söni (өдөр шөнө),

185§. ečige eke (эцэг эх),

278§. oroqu γarqu (орох гарах),

213§. bara’un jewün (баруун зүүн) гэх мэтээр 1. Муу гэх утга, 2. Сайн гэх утга, 3. Муу сайн гэх утга тус тус илэрхийлсэн түүхэн эсрэг утгат хоршоо үг тэр үеэс хэрэглэсээр өдгөө хүртэл улмаар олширсон байна.

2.6. Хэлцийн бүрэлдүүлбэрт эсрэг утгат үгсийг нэлээд сонгон хэрэглэж байжээ. Жишээ нь: 96§. Böğöre-yin **bögse-dür** čegere-yin **čegeji-dür** atuyay. (Бөөр нь бөгсөнд байг, цэр нь цээжинд байг. МНТ. 1957), 113§. ... **tenggiri yajar-a** kücü nemegdejü erketü **tenggiri-de** neryidcü eke **etügen-e** kürgejü ... (тэнгэр газарт хүч нэмэгдэж, эрхэт тэнгэрт нэрийдэж, эх этүгэнээ хүргэж ...МНТ. 2000), 124§. ... **qola**-yin qoocay, **oyira**-yin odora boltuyay keebe. (Холын холбогч, ойрын оторч /хол ойрыг сурвалжлах газарч/ болтугай. МНТ. 1957), 138§. ... **üdür** üjekü-yin nidün, **söni** sonsoqu-yin čikin ... (Өдөр үзэх нүд, шөнө сонсох чих. МНТ. 2000). Эдгээр жишээ баримтад “бөгс-цээж, тэнгэр-газар, тэнгэр-этүгэн, хол-ойр, өдөр-шөнө” гэсэн эсрэг утга үгийг сонгож, хэлц бүтээсэн явдал хэдэн зуун жилд монгол найруулгад үлгэр загвар болж иржээ.

“Монголын Нууц Товчоо”-ны хэлний өнгөн бүтэц ба гүн бүтцэд эрил хийж, хэл шинжлэлийн утга судлалын түвшний судлагдахууныг товчоолон тодорхойлсоор байвал, монгол хэлний түүхэн утга судлалын судалгаа урагшлах болно.

Дүгнэлт

“Монголын Нууц Товчоо”-ны хэлний үгийн сангийн нэгж хоорондын шүтэлцсэн ойролцоо ба эсрэг утгат үг, хэлц, өгүүлбэр бол монгол хэлний түүхэн утга судлалын сонирхолтой баримт бөгөөд цаашид дэлгэрүүлэн судлууштай юм.

Дунд үеийн монгол хэлний утга судлалын судалгааны асуудлыг нарийвчлан судлахад “МНТ” болон бусад дурсгалын хэлний баримтууд чухал хэрэгтэйн дээр орчин үеийн онолын утга судлалын үзэл баримтлалын үүднээс гүнзгий судалгаа явуулах шаардлагатай гэж үзэв.

“МНТ”-ны хэлний олон нэгжийн ойролцоо ба эсрэг утгыг ажиглах явцад зохиогчид нь хэлний гүн гүнзгий мэдлэгтэй байсан нь илэрхий мэдэгдэж байна.

Ном зүй

МНТ, 1957. Монголын Нууц Товчоо. Хоёр дахь удаагийн хэвлэл. Хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав. Улаанбаатар. 37, 45, 46, 52, 75.

МНТ, 1985. Монголын Нууц Товчоо. Галиглаж хэвлүүлсэн Т. Дашцэдэн. Уб. 216. /Галиг үсгээрх бүх жишээг энэ бүтээлээс эш татсан/

МНТ, 1990. Монголын Нууц Товчоо. Худам (язгуур эртний) монгол бичгээр монгол бичиг, утга судлалын үүднээс Ш. Гадамбын төсөөлөн нягталж, сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. Уб. 424.

МНТ, 2000. Монголын Нууц Товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Д. Цэрэнсодном. Уб. 47-48, 63, 77, 92.

Мөнхсайхан, С. 2023. Монголын нууц товчооны утга зүй, соёл, сэтгэлгээ. Уб. 200.

Пүрэвжав, Э. 2023. Монголын нууц товчоон судлалын ном зүй. Уб. 420.

Түмэндэмбэрэл, Ц. 2006. Монголын нууц товчооны хэлц хэллэг. Уб. 273.

Цэрэнсодном, Д. 2008. Монголын нууц товчооны утгазүй, уран сайхны шинжилгээ. Уб. 130.